

## НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 9 САРЫН ТАЙЛАН

Нийтийн номын сан нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний өдрийг “Эх хэлний өдөр” болгон тэмдэглэдэг уламжлалтай болсон.

Нийт ард иргэд, айл өрх, төрийн болон ТББ, ААН, бүх шатны сургалтын байгууллага “Эх хэлний өдрийн жил бүрийн энэ өдөр уламжлал болгон тэмдэглэхдээ бүх нийтээр монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, төрийн болон захиргааны албан хэрэг бичиг хөтлөлтийг Монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээнд нийцүүлэх, монгол хэл бичиг, кирилл үсгийн дүрмээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гарган ажиллах талаар зарлигт заасан байдаг.

Уг өдрийг тохиолдуулан Аймгийн Нийтийн номын сангийн зочноор сэтгүүлч, СОТА Я. Түмэннаст, Монгол хэл, уран зохиолын багш, Боловсролын тэргүүний ажилтан С. Оюунцэцэг нар уригдан оролцсон.



Соёл урлагийн ажилтны өдөр, 34 дэх Үндэсний номын баярыг угтан соёл урлагийн байгууллагууд "Миний мэргэжил-Миний бахархал", "Номын ертөнц-Номын орон зай" өдөрлөгийг 2023 оны 09 сарын 10-ны ням гаригт Жаахан шарга театрын гадна талбайд амжилттай зохион байгууллаа.

Тус өдөрлөгт нийтдээ давхардсан тоогоор 500 гаруй хүн хамрагдлаа. Сүхбаатар Аймгийн Нийтийн номын сангаас нийтдээ 150 гаруй номоор Шинэ номын үзэсгэлэн, Сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Шинэ ном, онцлог номын үзэсгэлэн худалдаа, байгууллага сурталчилсан мэдээлэл, Сэтгэл ханамжийн судалгааг орон нутгийн иргэддээ хүргэн ажиллалаа. Хүүхдийн уншлагын танхим нийтийн уншлагын танхимуудаас Номын баярыг угтан олон ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус өдөрлөгийн үеэр уншигчдын дунд Poetry open mic -Яруу найргийн нээлттэй мик арга хэмжээг явуулсан бөгөөд тус арга хэмжээнд төв хөдөөгийн яруу найрагчид, идэвхтэн бичигч, уншигч хүүхдүүд өдөрлөгт уригдан ирсэн бүх насныхан идэвхтэй оролцлоо. Нийтдээ 30 гаруй оролцогч өөрсдийн уран бүтээлээс болон уран яруу уншигчид ч бас зохиолч яруу найрагчдын бүтээлээс үзэгч олондоо толилууллаа.



34 дэх Үндэсний номын баярыг угтан "ҮЛГЭРЭЭС ҮЛГЭРЛЭЭ" аяны хүрээнд Мандарваа, 2, 3, 6, 11-р цэцэрлэгүүдийн бэлтгэл, ахлах, дунд, бага 17 бүлгийн хүүхэд багачуудад орос ардын үлгэр "Манжин" үлгэрээр хормогчин театр ашиглан үлгэр уншиж өглөө.



Соёл урлагийн байгууллагын албан хаагчдын "Соёл-Спорт" өдөрлөгт багаараа Тэргүүн байр эзлэн шилжин явах ЦОМ-ын эзэд болсон.



Үндэсний Номын баяр-2023 Сүхбаатар аймгийн Нийтийн номын сан, Зохиолчдын нэгдсэн эвлэлийн Сүхбаатар салбараас "Яруу увидас" арга хэмжээг зохион байгуулж, "Эх хэл-Бидний бахархал" цахим уралдаанд шалгарсан уншигч хүүхдүүдээ урамшуулж, уран бүтээлч О.Одхүүгийн уран бүтээлийн цэнгүүн зохион байгуулан алдаршуулж Соёлын гавъяа одонгоор шагналаа.



Аймгийн Нийтийн номын сангаас ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР-Т зориулж, Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон язгуур соёл, өв уламжлалаа эрхэмлэн дээдлэх, эх хэл, түүх соёлоо сурталчлах, иргэн бүр төрөлх монгол эх хэлээрээ зөв ярьж, зөв бичих, хүүхэд багачуудад эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор СӨБ-ын ахлах, бэлтгэл бүлэг, ЕБС-ийн 1-12 ангийн сурагчдын “ЭХ ХЭЛ - МИНИЙ БАХАРХАЛ” цахим шүлгийн уралдааныг явуулахад 18 сурагч оролцож,

Цэцэрлэгийн насны ангилалд:

Тэргүүн байр: А. Баяржаргал / Эрдэнэцагаан сумын 1-р цэцэрлэгийн Ахлах Б бүлгийн сурагч/

Дэд байр: Б.Мишээл /Түмэнцогт сумын Ахлах-Б бүлгийн суралцагч/

Гутгаар байр: Б. Буяндэлгэр /Сүхбаатар аймгийн 4-р цэцэрлэгийн Бэлтгэл а бүлгийн суралцагч/

ЕБС-ийн 1-5 ангийн ангилалд:

Тэргүүн байр: Б. Нандинцэцэг /Түмэнцогт сум 5б анги/

Дэд байр: У. Түвшинсайхан /Халзан сум ЕБС-ийн 5А ангийн сурагч/

Гутгаар байр: Ч. Намуун /2-р сургууль 5 анги /

6-12 ангийн ангилалд:

Тэргүүн байр: Д. Даваадорж /Эрдэнэцагаан сумын 12 анги/

Дэд байр: Г. Баярцэцэг /1-р сургууль 6е анги/

Гутгаар байр: Э. Ганганцэцэг /Түмэнцогт ЕБС-ийн 6б анги/ нар тус тус шалгарлаа.

Шагналыг МЗЭ-ийн эвлэлийн Сүхбаатар салбартай хамтран зохион байгуулсан "Яруу увдис" арга хэмжээн дээр гардуулж, шалгарсан хүүхдүүд маань шүлэг, яруу найргаасаа уншиж сонирхууллаа.



"Үндэсний бичиг соёл - номын өдрүүд 2023"

АННС-ийн НУТ-аас ЕБС-ын номын клубүүд, МСҮТ-ийн номын клубтай хамтран Дэлхийн болон Монголын шилдэг зохиол бүтээлүүдийг сурталчлан таниулах, Сурагчдыг номтой нөхөрлүүлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог "НОМ"-ын клубуудынхаа сурагчдыг дэмжиж урамшуулах зорилгоор



"АЯЛАГЧ-УНШИГЧ " уншлагыг клубын удирдагч багш нартай хамтран зохион байгууллаа

Багш нараасаа ном унших соёл, ач холбогдлыг сонсож, Уншсан номын хүүрнэл ярицлагаар хоорондоо мэтгэлцэж, Оюуны болон хөгжөөн баясгах тэмцээнүүдээр нөхөрсөгөөр уралдлаа. Уншигч хүүхдүүд маань Байгаль дэлхийгээ хайрлах сэтгэлээр орчны бохирдлыг цэвэрлэлээ.



НУТ-ын дэргэдэх "БИД-УНШИГЧ" клубын сурагчдын өглөөны уншлага. Энэ удаагийн уншлага Two bad Mice, Power Palace номуудаар хийгдэсэн.

Мөн "СУДАР ЭГШИГЛЭН" төсөлд Англи номын тэмдэглэлээр оролцож байгаа ба ээлжит уншлагаа "Two bad Mice" " Power Palace" номоор хийлээ Уншлагыг 4-р БДС-ийн Англи хэлний багш Ч. Нацагням удирдаж, 3-р БДС-ийн 12 ангийн сурагч Намуун урилгаар оролцлоо.



- Байгууллагын цахим хуудасаар тогтмол танин мэдэхүйн мэдээ, мэдээлэлийг тасралтгүй оруулж нийт 40 мэдээлэл оруулсан байна.

Статистак мэдээ:

Байнгын уншигч-771, ирэгсэд-4813, ном олголт - 4575